



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 08 сарын 18 өдөр

Дугаар A/68

Улаанбаатар хот

**Журам, жагсаалт шинэчлэн  
батлах тухай**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/216 дугаар тушаалын хавсралтаар баталсан журмын 3.4, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан 2022 оны А/118 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвөөс хүн амд үзүүлэх “Төлбөртэй тусламж, үйлчилгээний журам”-ыг нэгдүгээр, “Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан 2022 оны 02 сарын 28-ны өдрийн 49/А/118 дугаар тушаалын дагуу Баянзүрх эрүүл мэндийн төвөөс иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалт”-ыг хоёрдугаар, төлбөртэй тусламж үйлчилгээний төлбөрийн хэмжээг гуравдугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэхүү журмыг Эрүүл мэндийн төв болон харьяа нэгжүүдийн мэдээллийн самбарт болон байгууллагын сайтад ил тод нээлттэй байдлаар байршуулахыг Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын дарга, Даатгал статистик мэдээллийн албаны даатгалын мэргэжилтэн нарт тус тус үүрэг болгосугай.

3.Журмыг Эрүүл мэндийн төв болон харьяа салбар амбулаториуд, нэгдсэн эмнэлгүүдэд хариуцан хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга болон харьяа нэгжийн эрхлэгч, удирдлагуудад, мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн Орлогч дарга (Ш.Мөнхцэцэг)-т тус тус даалгасугай.

4.Төлбөрт үйлчилгээний төлбөрийг зохих хууль, журмын дагуу байгууллагын кассаар болон Төрийн сан дахь дансанд төвлөрүүлэхэд хяналт тавин, зарцуулалтыг тайлагнахыг Санхүү, нягтлан бодох, бүртгэлийн албаны дарга (Р.Цэнд-Аюуш)-т зөвшөөрсүгэй.

**1325000166**

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн (М.Байгальмаа)-д хариуцуулсугай.

ДАРГА

И.БАТЗАЯА



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨС  
ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД НЭМЭЛТ  
БОЛОН ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

- 1.1 Журмын зорилго, үндэслэл нь Эрүүл мэндийн төвөөс эрх бүхий албан тушаалтнуудын баталсан журам, жагсаалтаар баталсан төлбөрийн хэмжээний дагуу холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү журмыг Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудыг мөрдөж ажиллана.

**Хоёр.Тусламж, үйлчилгээний зохицуулалт**

- 2.1 Төлбөртэй тусламж үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээг үйлчлүүлэгчид үзүүлэхдээ байгууллагын үндсэн үйл ажиллагааг алдагдуулахгүй, мөн үйлчлүүлэгчдэд хүндрэл үүсгэхгүйгээр зохицуулах арга хэмжээг авна.
- 2.2 Үйлчилгээний төлбөрийг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг баримтлана.
- 2.3 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 18, 19 дүгээр зүйлд заасан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй үйлчилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтээр санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг баримтлан нэмэлтээр үзүүлж болох бөгөөд үйлчилгээний төлбөрийг үйлчлүүлэгч өөрөө хариуцна.
- 2.4 Эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлстэй холбоотой тусламж, үйлчилгээний төрөлд “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн дүгнэлт”-ийг хамааруулан ойлгох бөгөөд иргэн, аж ауйн нэгж, байгууллагын хүсэлтийн дагуу харилцан тохиролцож, хамтран ажиллах гэрээний дагуу үзлэг, шинжилгээ хийж болно.
- 2.5 Эрүүл мэндийн даатгалын багцад хамрагдаагүй бусад нэмэлт тусламж, үйлчилгээг иргэн, үйлчлүүлэгчийн хүсэлтэд үндэслэн тухайн тусламж, үйлчилгээний бодит өртгийг тооцсоны үндсэн дээр төлбөрийн жишиг хэмжээг тооцон үзүүлж болно.
- 2.6 Эрүүл мэндийн төвийн салбар нэгдсэн эмнэлгийн нийт батлагдсан орны 15 хувиас хэтрэхгүйгээр иргэний хүсэлтийн дагуу тав тух хангасан төлбөртэй өрөөг ажиллуулж болох бөгөөд тасгуудад жигд хуваарилж, үйлчлүүлэгчид сонголтыг бий болгож, зохицуулалтыг хийнэ.
- 2.7 Төлбөртэй тусламж, үйлчилгээ авч байсан иргэн өөрийн хүсэлтээр төлбөртэй

тусламж, үйлчилгээг зогсоох санал гаргасан тохиолдолд холбогдох зөвшөөрлийн хуудсыг бөглүүлж, тухайн тусламж, үйлчилгээг зогсоох хүртэл үзүүлсэн тусламж, үйлчилгээний төлбөрийг урьдчилан төлсөн төлбөрөөс хасагдуулж тооцон ямар нэгэн шимтгэл, хураамжгүйгээр төлбөр тооцоог хийж баримтжуулна. Урьдчилан төлөөгүй тохиолдолд иргэнээс бодит гарсан зардлаар төлбөрийг авна.

2.8 Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлж буй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардалд тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх үед хийгдсэн үндсэн оношилгоо, шинжилгээ, эм, эмнэлгийн хэрэгсэл, материал, бариа засал, нөхөн сэргээх эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээ багтах бөгөөд энэхүү зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас болон иргэнээс давхардуулан авахгүй. Даатгуулагчийн хариуцан төлөх хамтын төлбөрийн хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын дагуу шийдвэрлэнэ.

2.9 Энэхүү тушаалын хавсралтад тусгагдсан тусламж, үйлчилгээнээс бусад үйлчилгээнээс төлбөр авахыг хориглоно. Үүнд: ажлын бус цагаар үзүүлсэн тусламж, үйлчилгээ, шинжилгээний хариу өгөх, бие засах газар, нөмрөг, улавч, хувцас өлгөх, г.м нийтлэг үйлчилгээ хамаарна. Үйлчлүүлэгчийн автомашины зогсоол ашиглалтын төлбөрийг тухайн эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээ авсан тохиолдолд авахгүй.

2.10 Үйлчлүүлэгч өөрийн хүслэтээр төлбөртэй өрөөнд хэвтэн эмчлүүлснээр бусад ижил төрлийн тусламж, үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчээс илүү эмчилгээ, оношилгоо, шинжилгээ, асаргаа, сувилгаа авах, хөнгөлөлт эдлэх үндэслэл болохгүй.

2.11 Төлбөрийг Төрийн сан банкны 100200320001 дугаар бүхий Эрүүл мэндийн төвийн дансанд шилжүүлсний дараа үзлэг, шинжилгээг эхлүүлнэ.

### **Гурав. Төлбөртэй тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах**

3.1 Эрүүл мэндийн төвийн салбар нэгжүүд нь төлбөртэй тусламж, үйлчилгээтэй холбоотой дараах мэдээллийг мэдээллийн самбар, үйлчлүүлэгчийн хүлээлгийн танхим болон төлбөр хураах нэг цэгийн дэргэд иргэнд харагдахуйц, ойлгомжтой байдлаар байршуулах ба байгууллагын цахим хуудсанд байрлуулна. Үүнд:

3.1.1 Санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ;

3.1.2 Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх болон даатгуулагчийн төлөх хамтын төлбөрийн хэмжээ;

3.1.3 Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх зарим өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний жагсаалт, эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх болон даатгуулагчийн төлөх хамтын төлбөрийн хэмжээ

3.2 Иргэнээс энэхүү тушаалын хавсралтад заасан төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийг авахдаа улсын төсвөөс болон эрүүл мэндийн даатгалын

сангаас тухайн тусламж, үйлчилгээний төлбөрийг санхүүжүүлэхгүй байгаа шалтгааныг тайлбарлаж, иргэн зөвшөөрсний үндсэн дээр төлбөр авна.

3.3 Эрүүл мэндийн төвийн салбар нэгжүүд нь иргэнд төлбөр төлсөн баримтыг (и-баримт) заавал олгох бөгөөд уг баримтад эрүүл мэндийн төвийн салбар нэгжүүдийн нэр, үйлчлүүлэгчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, холбогдох төлбөрийн хэмжээ болон нийт төлбөрийн хэмжээ, огноог дор дурдсанаар ялгасан байна. Үүнд:

- ✓ Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцсан тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, нэр төрөл бүрээр
- ✓ Иргэний хариуцан төлөх тусламж, үйлчилгээний хамтын төлбөрийн хэмжээ
- ✓ Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний төлбөрийн хэмжээ, нэр төрөл бүрээр

#### **Дөрөв.Хяналт**

4.1 Төлбөртэй тусламж үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ нь байгууллагын үндсэн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх, байгууллагын үйл ажиллагааг доголдуулахгүй байх чиглэлээр төлбөрт үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

4.2 Төлбөртэй тусламж үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлого, зарлагын гүйцэтгэл болон төлбөрт үйлчилгээний хэрэгжилтийн байдалд дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн улирал бүр хяналт хийсэн байна.

#### **Тав.Хариуцлага**

4.1 Энэхүү журмыг зөрчсөн албан хаагч, албан тушаалтанд байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, гэрээнд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.

4.2 Иргэн эрүүл мэндийн байгууллагын нэмэлт үйлчилгээтэй холбоотой асуудлаар тухайн эрүүл мэндийн байгууллагын удирдлага, нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгуулалгад гомдол гаргах эрхтэй байна.



Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын  
2022 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн  
1168 тушаалын 2 дугаар хавсралт

Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан 2022 оны 02 сарын 28-ны өдрийн 49, А/118 дугаар тушаалын дагуу Баянзүрх Эрүүл Мэндийн Төвөөс иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалт

| №                      | Баримт бичгийн дугаарлалт | Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт | Тусламж, үйлчилгээний нэр төрөл                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | Код      | ЭМД-ын багцад хамаарах эсэх | Төлбөрийн жишиг хэмжээ |
|------------------------|---------------------------|----------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------|-----------------------------|------------------------|
| Лабораторийн шинжилгээ |                           |                                        |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |          |                             |                        |
| 1                      | 3                         | Бичил амьсудлалын шинжилгээ            | Бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ (шарх, хамар, хамар залгиур, залгиур, чих, нүд, умайн хүзүү, шээсний сүв, үтрээ, өтгөн, идээ, буглаа, цэр, шээс, гуурсны арчдас (трахеостом, интубац, хэвлий, цээж, давсаг, ЭДВ-н болон бусад гуурс), хатгалтын шингэн, цэр бронхийн угаагдасны нян судлалын шинжилгээ (хэвлий, плевр, тархи нугасны шингэн, үений шингэн, олгой цөс) | 10101003 | Тийм                        | 32,000                 |
| 2                      | 4                         | Бичил амьсудлалын шинжилгээ            | Нян тээгчийн шинжилгээ                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | 10101004 | Тийм                        | 30,000                 |
| 3                      | 5                         | Бичил амьсудлалын шинжилгээ            | Шинжлэгдэхүүнийг будаж шинжлэх-Грамммын будгийн арга                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | 10101005 | Тийм                        | 10,000                 |
| 4                      | 8                         | Бичил амьсудлалын шинжилгээ            | Цуснаас бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ                                                                                                                                                                                                                                                                                                                               | 10101008 | Тийм                        | 72,000                 |
| 5                      | 11                        | Биохимийн шинжилгээ                    | АЛАТ                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | 10102003 | Тийм                        | 3,000                  |
| 6                      | 12                        | Биохимийн шинжилгээ                    | Альбумин                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | 10102004 | Тийм                        | 3,000                  |
| 7                      | 14                        | Биохимийн шинжилгээ                    | Амилаза                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | 10102006 | Тийм                        | 5,000                  |

| №                      | Баримт<br>бичгийн<br>дугаарл<br>алт | Тусламж,<br>үйлчилгээний ерөнхий<br>жагсаалт | Тусламж, үйлчилгээний нэр төрөл                  | Код      | ЭМД-ын<br>багад<br>хамаара<br>х эсэх | Төлбөрийн жишиг<br>хэмжээ |
|------------------------|-------------------------------------|----------------------------------------------|--------------------------------------------------|----------|--------------------------------------|---------------------------|
| Лабораторийн шинжилгээ |                                     |                                              |                                                  |          |                                      |                           |
| 8                      | 17                                  | Биохимийн шинжилгээ                          | Антистрептолизин О тест (ASLO /ASO)<br>(тоогоор) | 10102009 | Тийм                                 | 10,000                    |
| 9                      | 18                                  | Биохимийн шинжилгээ                          | АСАТ                                             | 10102010 | Тийм                                 | 3,000                     |
| 10                     | 21                                  | Биохимийн шинжилгээ                          | Билирубин нийт                                   | 10102013 | Тийм                                 | 3,000                     |
| 11                     | 38                                  | Биохимийн шинжилгээ                          | Кальци                                           | 10102030 | Тийм                                 | 4,000                     |
| 12                     | 41                                  | Биохимийн шинжилгээ                          | Креатинин                                        | 10102033 | Тийм                                 | 4,000                     |
| 13                     | 56                                  | Биохимийн шинжилгээ                          | Магни                                            | 10102048 | Тийм                                 | 4,000                     |
| 14                     | 60                                  | Биохимийн шинжилгээ                          | Мочевин                                          | 10102052 | Тийм                                 | 4,000                     |
| 15                     | 65                                  | Биохимийн шинжилгээ                          | Нийт уураг                                       | 10102057 | Тийм                                 | 3,000                     |
| 16                     | 73                                  | Биохимийн шинжилгээ                          | Преальбумин                                      | 10102065 | Тийм                                 | 8,000                     |
| 17                     | 78                                  | Биохимийн шинжилгээ                          | Темер                                            | 10102070 | Тийм                                 | 4,000                     |
| 18                     | 80                                  | Биохимийн шинжилгээ                          | Триглицерид                                      | 10102072 | Тийм                                 | 3,000                     |
| 19                     | 83                                  | Биохимийн шинжилгээ                          | Фосфор                                           | 10102075 | Тийм                                 | 3,000                     |
| 20                     | 89                                  | Биохимийн шинжилгээ                          | Холестерин                                       | 10102081 | Тийм                                 | 3,000                     |
| 21                     | 94                                  | Биохимийн шинжилгээ                          | Шүлтлэг фосфотаза                                | 10102086 | Тийм                                 | 4,000                     |
| 22                     | 99                                  | Биохимийн шинжилгээ                          | Шээсний хүчил (цус)                              | 10102091 | Тийм                                 | 3,000                     |
| 23                     | 121                                 | Гематологийн<br>шинжилгээ                    | Цочмог болон архаг лейкоз оношилгоо              | 10104007 | Тийм                                 | 850,000                   |
| 24                     | 122                                 | Гематологийн<br>шинжилгээ                    | Цусны дэлгэрэнгүй шинжилгээ                      | 10104008 | Тийм                                 | 14,000                    |
| 25                     | 166                                 | Иммуно гематологийн<br>шинжилгээ             | Цусны бүлэг, резус                               | 10105044 | Тийм                                 | 11,000                    |
| 26                     | 234                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | РАРР-А                                           | 10106065 | Тийм                                 | 30,000                    |
| 27                     | 235                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | PIVKA II                                         | 10106066 | Тийм                                 | 60,000                    |

| №                      | Баримт<br>бичгийн<br>дугаарл<br>алт | Тусламж,<br>үйлчилгээний ерөнхий<br>жагсаалт | Тусламж, үйлчилгээний нэр төрөл                                                                                                                                                     | Код      | ЭМД-ын<br>багцад<br>хамаара<br>х эсэх | Төлбөрийн жишиг<br>хэмжээ |
|------------------------|-------------------------------------|----------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------|---------------------------------------|---------------------------|
| Лабораторийн шинжилгээ |                                     |                                              |                                                                                                                                                                                     |          |                                       |                           |
| 28                     | 236                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | pro BNP                                                                                                                                                                             | 10106067 | Тийм                                  | 100,000                   |
| 29                     | 242                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | RT-PCR үндсэн 7 үүсгэгч (Trichomonas vaginalis, Mycoplasma hominis, Mycoplasma genitalium, Chlamydia trachomatis, Neisseria gonorrhoeae, Ureaplasma parvum, Ureaplasma urealyticum) | 10106073 | Тийм                                  | 165,000                   |
| 30                     | 267                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Бүдүүн гэдэсний CEA                                                                                                                                                                 | 10106098 | Тийм                                  | 22,000                    |
| 31                     | 277                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Витамин Д3 /25-оН/                                                                                                                                                                  | 10106108 | Тийм                                  | 36,000                    |
| 32                     | 281                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Глюкозжсон гемоглобин                                                                                                                                                               | 10106112 | Тийм                                  | 17,000                    |
| 33                     | 285                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | ДОХ (HIV cassette)                                                                                                                                                                  | 10106116 | Тийм                                  | 6,000                     |
| 34                     | 299                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Инсулин (Insulin)                                                                                                                                                                   | 10106130 | Тийм                                  | 25,000                    |
| 35                     | 310                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Өндгөвчний хавдрын маркер-CA 125-II                                                                                                                                                 | 10106141 | Тийм                                  | 25,000                    |
| 36                     | 316                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Өтгөнд хеликобактер тодорхойлох                                                                                                                                                     | 10106147 | Тийм                                  | 20,000                    |
| 37                     | 322                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | С вирусийн эсрэг эсрэг бие (aHCV) электрохимлюминесценц                                                                                                                             | 10106153 | Тийм                                  | 25,000                    |
| 38                     | 323                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | С пептид (C-peptide)                                                                                                                                                                | 10106154 | Тийм                                  | 23,000                    |
| 39                     | 327                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Тиреод сэдээгч даавар (TSH)                                                                                                                                                         | 10106158 | Тийм                                  | 17,000                    |
| 40                     | 329                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Тироглобулины эсрэг бие (anti TG)                                                                                                                                                   | 10106160 | Тийм                                  | 20,000                    |

| №                      | Баримт<br>бичгийн<br>дугаарл<br>алт | Тусламж,<br>үйлчилгээний ерөнхий<br>жагсаалт | Тусламж, үйлчилгээний нэр төрөл                                                                                    | Код      | ЭМД-ын<br>багцад<br>хамаара<br>х эсэх | Төлбөрийн жишиг<br>хэмжээ |
|------------------------|-------------------------------------|----------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------|----------|---------------------------------------|---------------------------|
| Лабораторийн шинжилгээ |                                     |                                              |                                                                                                                    |          |                                       |                           |
| 41                     | 332                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Токсоплазм вирусийн хурц халдвар (Toxo IgM) электрохимолуминесценц                                                 | 10106163 | Тийм                                  | 22,000                    |
| 42                     | 338                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Түрүү булчирхайн хавдрын маркер (PSA)                                                                              | 10106169 | Тийм                                  | 21,000                    |
| 43                     | 341                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Тэмбүү илрүүлэх өвөрмөц сорил (TPHA)                                                                               | 10106172 | Тийм                                  | 5,000                     |
| 44                     | 351                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Улаанууд вирусийн хурц халдвар (Rubella IgM) электрохимолуминесценц                                                | 10106182 | Тийм                                  | 23,000                    |
| 45                     | 354                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Ферритин (Ferritin)                                                                                                | 10106185 | Тийм                                  | 26,000                    |
| 46                     | 373                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Хепатитын В вирусийн гадаргуугийн эсрэг биеийн үзүүлэлт (HBsAg) cassette                                           | 10106204 | Тийм                                  | 6,000                     |
| 47                     | 374                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Хепатитын В вирусийн гадаргуугийн эсрэг биеийн үзүүлэлтийг тоолох аргаар үзэх (HBsAg quant) электрохимолуминесценц | 10106205 | Тийм                                  | 60,000                    |
| 48                     | 375                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Хепатитын С вирусийн эсрэг бие (anti-HCV) cassette                                                                 | 10106206 | Тийм                                  | 6,000                     |
| 49                     | 376                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Нойр булчирхайн хавдрын маркер (CA 19-9)                                                                           | 10106207 | Тийм                                  | 30,000                    |
| 50                     | 377                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Ходоодны хавдрын маркер (CA 72-4)                                                                                  | 10106208 | Тийм                                  | 35,000                    |
| 51                     | 378                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Хөхний хавдрын маркер (CA 15-3)                                                                                    | 10106209 | Тийм                                  | 35,000                    |
| 52                     | 384                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Цитомегаловирус капсид уургийн эсрэг IgM электрохимолуминесценц                                                    | 10106215 | Тийм                                  | 30,000                    |
| 53                     | 386                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Чөлөөт Тироксин даавар (FT4)                                                                                       | 10106217 | Тийм                                  | 15,000                    |
| 54                     | 387                                 | Иммунологийн<br>шинжилгээ                    | Чөлөөт Триидотиронин даавар (FT3)                                                                                  | 10106218 | Тийм                                  | 20,000                    |

| №                      | Баримт<br>бичгийн<br>дугаарл<br>алт | Тусламж,<br>үйлчилгээний ерөнхий<br>жагсаалт    | Тусламж, үйлчилгээний нэр төрөл                   | Код      | ЭМД-ын<br>багцад<br>хамаара<br>х эсэх | Төлбөрийн жишиг<br>хэмжээ |
|------------------------|-------------------------------------|-------------------------------------------------|---------------------------------------------------|----------|---------------------------------------|---------------------------|
| Лабораторийн шинжилгээ |                                     |                                                 |                                                   |          |                                       |                           |
| 55                     | 399                                 | Иммунологийн<br>шинжилгээ                       | Элэгний хавдрын маркер (AFP)                      | 10106230 | Тийм                                  | 20,000                    |
| 56                     | 425                                 | Молекул биологийн<br>шинжилгээ                  | Xpert MTB/RIF                                     | 10107019 | Тийм                                  | 30,000                    |
| 57                     | 436                                 | Халдварын молекул<br>шинжилгээ                  | Бэлгийн замаар дамжих халдварын<br>илрүүлэг       | 10108006 | Тийм                                  | 150,000                   |
| 58                     | 466                                 | Цус бүлэгнэлтийн<br>шинжилгээ<br>(коагулограмм) | АРТТ                                              | 10109001 | Тийм                                  | 5,000                     |
| 59                     | 477                                 | Цус бүлэгнэлтийн<br>шинжилгээ<br>(коагулограмм) | ТТ                                                | 10109012 | Тийм                                  | 5,000                     |
| 60                     | 484                                 | Цус бүлэгнэлтийн<br>шинжилгээ<br>(коагулограмм) | РТ (INR)                                          | 10109019 | Тийм                                  | 5,000                     |
| 61                     | 499                                 | Шимэгч судлалын<br>шинжилгээ                    | Шимэгч хорхойн өндөг илрүүлэг /натив<br>харах/    | 10110013 | Тийм                                  | 5,000                     |
| 62                     | 528                                 | Эд эсийн шинжилгээ                              | Цитологи шинжилгээ                                | 10112004 | Тийм                                  | 10,000                    |
| 63                     | 539                                 | Эмнэлзүйн химийн<br>шинжилгээ                   | Өтгөнд далд цус тодорхойлох                       | 10113009 | Тийм                                  | 12,000                    |
| 64                     | 544                                 | Эмнэлзүйн химийн<br>шинжилгээ                   | Үтрээний наалдцын шинжилгээ                       | 10113014 | Тийм                                  | 13,000                    |
| 65                     | 549                                 | Эмнэлзүйн химийн<br>шинжилгээ                   | Шээсний ерөнхий шинжилгээ                         | 10113019 | Тийм                                  | 6,000                     |
| 66                     | 584                                 | Молекул генетикийн<br>шинжилгээ                 | Цусны хавдрын Филадельфия хромосом<br>тодорхойлох | 10116024 | Тийм                                  | 50,000                    |
| 67                     | 585                                 | Молекул генетикийн<br>шинжилгээ                 | Пренатал илрүүлэг (Хоёрол тест)                   | 10116025 | Тийм                                  | 120,000                   |

| №                                              | Баримт<br>бичгийн<br>дугаарл<br>алт | Тусламж,<br>үйлчилгээний ерөнхий<br>жагсаалт | Тусламж, үйлчилгээний нэр төрөл                                                                                                                                                                                               | Код      | ЭМД-ын<br>багцад<br>хамаара<br>х эсэх | Төлбөрийн жишиг<br>хэмжээ |
|------------------------------------------------|-------------------------------------|----------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------|---------------------------------------|---------------------------|
| Лабораторийн шинжилгээ                         |                                     |                                              |                                                                                                                                                                                                                               |          |                                       |                           |
| Оношилгооны ажилбар, хэмжилт, сорил, шинжилгээ |                                     |                                              |                                                                                                                                                                                                                               |          |                                       |                           |
| 68                                             | 599                                 | Бүх төрлийн уян<br>дурангийн оношилгоо       | Уян дуран (Бүдүүн гэдэс, уушги, улаан<br>хоолой ходоод, төвөнх)                                                                                                                                                               | 10202003 | Тийм                                  | 70,000                    |
